

А. Хуучин ИНД-үүдэд **altitude**, **height** үгсийг хэрэглэсэн талаар

1. Өмнөх үг

Өмнө нь ИНД-үүдэд “**altitude**”, “**height**”, “**level**”, “**elevation**” - зэрэг англи үгсийг бүгдийг нь орос орчуулгаас монгол хэл руу дамжуулан бүгдийг нь “**өндөр**” гэж 1 үгээр орчуулан хэрэглэж байжээ.

- Англиас орос руу, дараа нь оросоос монгол руу дамжуулан дараах байдлаар орчуулан хэрэглэж байжээ:

Англи	Орос	Орос - Монгол	
Altitude	абсолютная высота	үнэмлэхүй өндөр	Хүчингүй болсон ИНД-д хааяа хэрэглэснээс өөрөөр бусад бичиг баримтад “үнэмлэхүй өндөр”, “харьцангуй өндөр” гэж огт хэрэглэдэггүй, нийтлэг бус үг хэллэг.
Height	относительная высота	харьцангуй өндөр	
Level	эшелон	цуваа	Хүчингүй болсон ИНД-ээс бусад бичиг баримтад “ өндрийн цуваа ”, “ цувааны өндөр ”, “ босоо цуваачлал ” гэж хэрэглэдэггүй, нийтлэг бус үг хэллэг. Монгол хэлэнд “түвшин” гэж хэрэглэдэг.
Elevation	превышение	өндөр	Монгол хэлэнд “ өндөрлөг ” гэж хэрэглэдэг.

- Хэрэв англиас монгол руу шууд орчуулбал дараах утгыг илэрхийлж байна:

Англи	Англи - Монгол (Болор толь)	Тодорхойлолт
Altitude	түвшин (“өндрийн-түвшин” болгох саналтай)	Түвшин / Altitude гэж далайн дундаж түвшнээс хэмжсэн, түвшин , цэг, эсхүл цэг гэж үзсэн байгууламжийн босоо зайг;
Height	өндөр	Өндөр / Height гэж тогтоосон эхлэлийн цэгээс хэмжсэн бөгөөд тухайн байгууламжийн босоо хэмжээг багтаасан, түвшин, цэг, эсхүл цэг гэж үзсэн байгууламжийн босоо зайг;
Level	түвшин	Түвшин / Level гэж нислэгт байгаа агаарын хөлгийн босоо байршилтай холбоотой өндөр, түвшин , эсхүл нислэгийн түвшнийг илэрхийлдэг олон утгатай ерөнхий ойлголтыг;
Elevation	өндөрлөг	Өндөрлөг / Elevation гэж далайн дундаж түвшнээс хэмжсэн, газрын гадаргуу дээр, эсхүл түүнд бэхэлсэн цэгийн, эсхүл түвшний босоо зайг;

2. Хүчингүй болсон ИНД-үүдэд хэрэглэсэн байдал:

2010 оны хүчингүй болсон үндсэн 48 ИНД-д “**өндөр**” гэж 884 удаа хэрэглэсэн бөгөөд үүнээс:

- “**харьцангуй өндөр**” гэж 26 удаа,
- “**үнэмлэхүй өндөр**” гэж 52 удаа орсон байна.

ИНД-д 806 удаа (884-(52+26)) **харьцангуй**, эсхүл **үнэмлэхүй** гэж ялгалгүй дан “**өндөр**” гэдэг нэг үгээр орчуулан хэрэглэсэн нь **height, altitude, level, elevation**-ний аль болохыг ойлгомжгүй болгосон. Үндсэн 48 ИНД-үүдэд “**өндөр**” гэдэг үгийг “**харьцангуй**, эсхүл **үнэмлэхүй өндөр**”-ийг **9%**-д нь зөв, үлдсэн **91%**-ийг **буруу** тодорхойлж хэрэглэж байсан нь орос хэлнээс махчлан орчуулан авсан дээрх үг хэллэг иргэний нисэхэд огт хэвшээгүй болохыг батлан харуулж байна.

Хуучин ИНД-д “**height**”-ийг “**харьцангуй өндөр**”, “**altitude**”-ийг “**үнэмлэхүй өндөр**” гэж орос хэлнээс шууд орчуулан тодорхойлохыг оролдсон боловч хооронд нь андуурч, хольсон ба **height, altitude, level, elevation** болон тэдгээртэй холбоотой TA, TL, MDA, MDH, DA, DH ойлголтуудыг алдаатай, тодорхойгүй байдлаар хэрэглэдэг байжээ.

Хуучин англи дүрмийн эх үүсвэрт		2010 оны хүчингүй болсон ИНД		Батлагдсан ИНД
Altitude - 19 ИНД-д	299 удаа	үнэмлэхүй өндөр - 6 ИНД-д 52 удаа	бусдыг “өндөр” гэж оруулсан	Түвшин (“өндрийн-түвшин” болгох саналтай)
Height - 21 ИНД-д	186 удаа	харьцангуй өндөр - 5 ИНД-д 26 удаа	бусдыг “өндөр” гэж оруулсан	Өндөр
Flight level - 7 ИНД-д	64 удаа	2010 оны ИНД-д flight level гэдэг үгийг дараах байдлаар, 8 янзаар орчуулсан байдаг: <ol style="list-style-type: none"> 1. Нислэгийн түвшин (ИНД-1, Cruising level / Чиг шулуун нислэгийн түвшин) 2. Нислэгийн өндөр (ИНД-1, 133, 135, 172, 175, 43, 61, 71, 91) 3. Нислэгийн өндрийн цуваа (ИНД-1, 91) 4. Нислэгийн өндрийн цуваачлал (ИНД-91) 5. Нислэгийн цуваа (ИНД-104, 172, 71, 73, 75, 95) 6. Нислэгийн цуваачлал (ИНД-172) 7. Өндрийн цуваачлал (ИНД-91) 8. Цувааны өндөр (ИНД-91) 9. Босоо цуваачлал (ИНД-91) 10. FL (ИНД-91, 95) 		Нислэгийн түвшин
Elevation - 7 ИНД-д	28 удаа	өндөр		Өндөрлөг

3. ИНД-91-д altitude, height, level-ийг хэрхэн хэрэглэсэн талаар:

2010 оны ИНД-91-д altitude, height, level, elevation гэдэг үгсийг нийт 266 удаа “өндөр” гэж хэрэглэжээ. Үүнд:

Англи	тоо	2010 оны ИНД	Батлагдсан ИНД-91	Санал
altitude	22	үнэмлэхүй өндөр	түвшин	өндрийн-түвшин
altitude	16	нислэгийн өндөр	түвшин	өндрийн-түвшин
minimum altitudes	6	аюулгүй нам өндөр	минимум түвшин	минимум өндрийн-түвшин
transition altitude	7	шилжих өндөр	шилжих түвшин	шилжих өндрийн-түвшин
height	3	харьцангуй өндөр	өндөр	өндөр
minimum heights	6	аюулгүй өндөр	минимум өндөр	минимум өндөр
transition level	4	шилжих цуваа	шилжих нислэгийн түвшин	шилжих нислэгийн түвшин
flight level	4	1. өндрийн цуваачлал	нислэгийн түвшин	нислэгийн түвшин
	3	2. нислэгийн өндрийн цуваачлал		
	4	3. цувааны өндөр		
	9	4. нислэгийн өндрийн цуваа		
	1	5. босоо цуваачлал		
	6	6. нислэгийн өндөр		
	2	7. FL		
DA (decision altitude)	1	шийдвэр гаргах үнэмлэхүй өндөр	шийдвэр гаргах түвшин	шийдвэр гаргах өндрийн-түвшин
DH (decision height)	1	шийдвэр гаргах харьцангуй өндөр	шийдвэр гаргах өндөр	шийдвэр гаргах өндөр
altitude, height	169	өндөр	169 удаа дан “өндөр” гэж орчуулсан нь height, altitude-ийг харьцангуй, эсхүл үнэмлэхүй аль болох нь ойлгомжгүй болгосон.	

Тайлбар:

Нийт 144 “height”, “altitude” нэр томъёоноос зөвхөн 27 удаа “үнэмлэхүй болон харьцангуй өндөр” гэж ялгасан ба үлдсэн 119-г “өндөр” гэж орчуулсан нь “height”, “altitude”-г “харьцангуй, эсхүл үнэмлэхүй өндөр”-ийн аль болохыг нь ойлгомжгүй хэрэглэсэн.

Үүнээс харахад бид хэдий “height”-ийг “харьцангуй өндөр”, “altitude”-ийг “үнэмлэхүй өндөр” гэж томъёолсон боловч Нислэгийн ерөнхий дүрэм ИНД-91-т эдгээр үгсийг 27 удаа буюу 19%-ийг нь л зөв, үлдсэн 119 удаа буюу 81%-ийг буруу тодорхойлж хэрэглэж байсан нь орос хэлнээс махчлан орчуулан авсан дээрх үг хэллэг Нислэгийн ерөнхий дүрэмд ч огт хэвшээгүй болохыг харуулж байна.

В. Батлагдсан ИНД-үүдэд **altitude**, **height**, **level** зэрэг үгсийг хэрэглэсэн талаар

1. Ерөнхий

Хүчингүй болсон ИНД-үүдэд хэрэглэсэн “**altitude**”, “**height**” англи үгсийн орчуулгын талаар агаарын тээвэрлэгчид болон нисгэгчдийн төлөөлөлтэй санал солилцож “**үнэмлэхүй өндөр**”, “**харьцангуй өндөр**” гэж хэрэглэх нь зохимжгүй байгаа нь тодорхой харагдаж байгаа тул цаашид ийм байдлаар хэрэглэх нь буруу гэдэг дээр санал нэгдсэн.

Мөн <https://legalinfo.mn>-оос “**үнэмлэхүй өндөр**”, “**харьцангуй өндөр**” гэдэг үгийн хайлт хийхэд хүчингүй болсон ИНД болон Нислэгийн цаг уурын журмаас бусад дараах 1 хууль, 2 журамд нийт 3-хан удаа дараах байдлаар хэрэглэсэн нь “**үнэмлэхүй өндөр**”, “**харьцангуй өндөр**” гэдэг үг хэллэг Монгол Улсын хууль, эрх зүйн баримт бичигт хэрэглэж хэвшээгүй болох нь тодорхой харагдаж байна:

<https://legalinfo.mn>-ээс “**үнэмлэхүй өндөр**” гэж хайлт хийвэл:

- **Монгол Улсын хуульд:** огт хэрэглээгүй.
- **Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо монгол улсын барилгын норм ба дүрэм**
Газрын доорхи усны хими, бактерлогийн шинжилгээний үр дүнгийн хүснэгтүүд, гидрогеологийн параметруудийг тооцсон арга, томъёо, үр дүн, өрөмдлөгийн ажлууд, ажиглалтын цэгийн солбицол, **үнэмлэхүй өндөр**;

<https://legalinfo.mn>-ээс “**харьцангуй өндөр**” гэж хайлт хийвэл:

- **Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай 1999:**
5.2.Бүх ангиллын кадастрын зургийг мөрдөж байгаа зураг зүйн тусгаг, байр зүйн хавтгайн тогтолцоонд өргөрөг, уртрагийн өнцгийн болон далайн түвшнээс дээших **харьцангуй өндрийн** тоон хэмжээсээр тус тус илэрхийлнэ.
- **Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх /БНБД 22-01-21/ барилгын норм, дүрэм**
6.7.2. Гулзайлт ба төвийн бус шахалтанд ажиллах элементийн нормаль огтлолын бат бэхийг тооцохдоо бетоны шахалтын бүсийн **харьцангуй өндрийн** хязгаарын утга $\xi_{\text{B}}-\text{II}$ -ийг “Бетон ба төмөрбетон бүтээц”-ийн норм, дүрэмд зааснаар авч тооцооны газар хөдлөлтийн 7 баллд-0,85, 8 баллд-0,7, 9баллд-0,5 гэсэн илтгэлцүүрээр үржүүлж хэрэглэнэ.

Иймд 2019, 2021 онд шинэчлэн батлагдсан ИНД-үүдэд “**altitude**”, “**height**”, “**level**”, “**elevation**” - зэрэг англи үгсийг үгсийг дараах байдлаар орчуулан хэрэглэх нь тохиромжтой гэж үзсэн. Үүнд:


- “**elevation** - өндөрлөг”,
- “**level** - түвшин”,
- “**height** - өндөр”,
- “**altitude** - түвшин” (“**өндрийн-түвшин**” гэж солих санал гарсан).

2. “Flight level” болон “altitude” нэр томъёоны талаар

“Altitude” болон “level”-ийг “түвшин” гэж 1 үгээр орчуулсан нь ойлгомжгүй байж магадгүй гэсэн үндэслэлээр **altitude**-ийг “**өндрийн-түвшин**” гэж солихоор гаргасан саналын дагуу энэ нэмэлт мэдээллийг бэлтгэлээ.

- “**Flight Level**” гэж “**transition level (TL)**”-ээс (манай хувьд 4500 м / 15 000 ft) дээших “**нислэгийн түвшин**”-ийг илэрхийлэхэд хэрэглэдэг.
- “**Altitude**” гэж “**transition altitude (TA)**”-аас (манай хувьд 3900 м / 13 000 ft) дооших “**түвшин**”, эсхүл “**өндрийн-түвшин**”-ийг илэрхийлэхэд хэрэглэнэ.

“**Flight Level**”-ийг “**нислэгийн түвшин**”, “**altitude**”-ийг “**түвшин**”, эсхүл “**өндрийн-түвшин**” гэж тодорхойлоход хоорондоо ямар ч зөрчлийг үүсэхгүй гэж үзэж байна.



- “Level” - ойлголтын талаар:

Тодорхойлолт:

Level / Түвшин гэж нислэгт байгаа агаарын хөлгийн босоо байршилтай холбоотой **өндөр**, **түвшин**, эсхүл **нислэгийн түвшнийг** илэрхийлдэг олон утгатай ерөнхий ойлголтыг;

Level is a generic term relating to the vertical position of an aircraft in flight and meaning variously **height**, **altitude**, or **flight level**:

Англи	Хуучин ИНД	Батлагдсан ИНД
flight level	<ol style="list-style-type: none"> 1. нислэгийн түвшин 2. нислэгийн өндөр, 3. нислэгийн өндрийн цуваа, 4. нислэгийн өндрийн цуваачлал, 5. нислэгийн цуваа, 6. нислэгийн цуваачлал, 7. өндрийн цуваачлал, 8. цувааны өндөр, 9. босоо цуваачлал 10. FL 	нислэгийн түвшин
cruising level	чиг шулуун нислэгийн түвшин	аяллын түвшин
transition level (TL)	-	шилжих нислэгийн түвшин
sea level	далайн түвшин	далайн түвшин
above ground level (AGL)	газрын түвшнээс дээш	газрын түвшнээс дээш
above mean sea level (AMSL)	далайн дундаж түвшнээс дээш	далайн дундаж түвшнээс дээш

Монгол хэлний их тайлбар тольд: (<https://mongoltoli.mn/>) **Цуваа** гэж:

- **Цувж яваа хүн, амьтан, хөсөг тэрэг:** галуун цуваа, жингийн цуваа, цэргийн цуваа;
- **Адуу малын жим зам:** цуваа зам, уваа цуваа
- **Галт тэрэгний нэг бүрэлдэхүүн:** нэг цуваа галт тэрэг явж өнгөрөх (галт тэрэгний нэг бүрэлдэхүүн) (Эшелон).

“Цуваа” нь хэвтээ тэнхлэгт ар араасаа цувж байрлах гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд “босоо цуваа” гэсэн ойлголт байдаггүй.

“Цуваа” нь байрлал тодорхойлдоггүй бөгөөд өндөр болон түвшний тухай ойлголтыг өөртөө агуулдаггүй.

Дүгнэлт:

Дээрх хүснэгтээс дүгнэхэд **“level”** гэдэг үгийг **“түвшин”** гэж хэрэглэж хэвшсэн тул 10 янзаар орчуулж хэрэглэдэг байсан **“flight Level”**-г **“нислэгийн түвшин”** гэж 1 мөр хэрэглэж хэвших нь зүйтэй.

- “Altitude” - ойлголтын талаар:

Тодорхойлолт:

Altitude / Түвшин (“**өндрийн-түвшин**” болгох саналтай) гэж далайн дундаж түвшнээс хэмжсэн, **түвшин**, цэг, эсхүл цэг гэж үзсэн байгууламжийн босоо зай;

Altitude means the vertical distance of a **level**, a point, or an object considered as a point, measured from mean sea level:

Англи	Хуучин ИНД	Батлагдсан ИНД	
		Түвшин (батлагдсан)	Өндрийн-түвшин (солих санал)
altitude (299)	<ul style="list-style-type: none"> - өндөр - үнэмлэхүй өндөр (52 удаа, ИНД-1, ИНД-12, ИНД-91, ИНД-95, ИНД-104, ИНД-175) 	түвшин	өндрийн-түвшин
cruising altitude (12)	<ul style="list-style-type: none"> - чиг шулуун нислэгийн үнэмлэхүй өндөр (0) - чиг шулуун нислэгийн өндөр (3 удаа, ИНД-104) - чиг шулуун нислэг (1 удаа, ИНД-121) - нислэг үйлдэх өндөр (2 удаа, ИНД-71) - нислэгийн үнэмлэхүй өндөр (3 удаа, ИНД-91) 	аяллын түвшин	аяллын өндрийн-түвшин
sensitive pressure altitude (4)	<ul style="list-style-type: none"> - даралтаар хэмжигдэх өндөр (1 удаа, ИНД-121) - өндрийг даралтаар хэмжих (1 удаа, ИНД-135) - барометрийн өндөр (1 удаа, ИНД-91) 	даралтаар илэрхийлдэг түвшин	даралтаар илэрхийлдэг өндрийн-түвшин
minimum altitude (9)	<ul style="list-style-type: none"> - аюулгүй нам өндөр (5 удаа, ИНД-91) - хамгийн бага үнэмлэхүй өндөр (17 удаа, ИНД-91(1); ИНД-95(6); ИНД-175(2); ИНД-12(1); ИНД-1(7)) - хамгийн бага өндөр (11 удаа) 	минимум түвшин	минимум өндрийн-түвшин
safe altitude (8)	<ul style="list-style-type: none"> - аюулгүйн өндөр (3 удаа, ИНД-91(1); ИНД-135(2)) - аюулгүй өндөр (4 удаа, ИНД-135(1); ИНД-75(2); ИНД-77(1)) - аюулгүй үнэмлэхүй өндөр (6 удаа, ИНД-95) 	аюулгүй түвшин	аюулгүй өндрийн-түвшин
minimum descent altitude (2) MDA (16)	<ul style="list-style-type: none"> - доошилж болох хамгийн бага үнэмлэхүй өндөр (2 удаа, ИНД-1) - доошилж болох хамгийн бага өндөр (1 удаа, ИНД-91) - доошилж болох өндөр /MDA/ (1 удаа, ИНД-91) - доошлох хамгийн бага үнэмлэхүй өндөр (1 удаа, ИНД-12) - MDA (14 удаа, ИНД-1(1); ИНД-12(1); ИНД-91(12)) 	өндөр алдах минимум түвшин	өндөр алдах минимум өндрийн-түвшин
minimum parachute activation altitude (2)	<ul style="list-style-type: none"> - шүхэр задлах хамгийн бага өндөр (2 удаа, ИНД-105) 	шүхэр задлах минимум түвшин	шүхэр задлах минимум өндрийн-түвшин

decision altitude (2) DA (13)	- шийдвэр гаргах үнэмлэхүй өндөр (2 удаа, ИНД-1) - шийдвэр гаргах өндөр (16 удаа, ИНД-1, ИНД-12, ИНД-91, ИНД-121, ИНД-135) - DA (15 удаа, ИНД-1, ИНД-91)	шийдвэр гаргах түвшин	шийдвэр гаргах өндрийн-түвшин
transition altitude (2) TA (2)	- шилжилтийн өндөр (2 удаа, ИНД-1) - шилжих өндөр (7 удаа, ИНД-91) - шилжих үнэмлэхүй өндөр (3 удаа, ИНД-91)	шилжих түвшин	шилжих өндрийн-түвшин
operating altitude (4)	- нислэгийн өндөр (1 удаа, ИНД-43) - өндөр (1 удаа, ИНД-91) - нислэгийн үнэмлэхүй өндөр (1 удаа, ИНД-91)	үйл ажиллагааны түвшин	үйл ажиллагааны өндрийн-түвшин
highest practical altitude (1)	-	хамгийн их боломжит түвшин	хамгийн их боломжит өндрийн-түвшин
assigned altitude indicator (2)	- тогтоосон өндрийг заагч (1 удаа, ИНД-91)	оноосон түвшнийг заах хэрэглэл	оноосон өндрийн-түвшнийг заах хэрэглэл
altitude alerting system (8)	- өндөр дохиологч систем (1 удаа, ИНД-91) - өндрийн дохиоллын систем (2 удаа, ИНД-91) - өндөр дохиолох систем (2 удаа, ИНД-91)	түвшнийг анхааруулах систем	өндрийн-түвшнийг анхааруулах систем
altitude encoder equipment (2)	- өндрийн мэдээллийг кодлох тоноглол	түвшний мэдээлэл кодлох төхөөрөмж	өндрийн-түвшний мэдээлэл кодлох төхөөрөмж

Дүгнэлт:

Дээрх хүснэгтээс дүгнэхэд **“altitude”** гэдэг үгийг **“үнэмлэхүй өндөр”** гэж хэрэглэхээр томъёолсон боловч нийт 19 ИНД-д 299 удаа хэрэглэх байснаас 52 удаа буюу 17%-ийг “үнэмлэхүй өндөр” гэж зөв хэрэглэсэн, үлдсэн нь 83%-ийг буруу тодорхойлж хэрэглэж байсан нь орос хэлнээс махчлан орчуулан авсан дээрх үг хэллэг иргэний нисэхэд огт хэвшээгүй болохыг батлан харуулж байна.

“Altitude / Түвшин (**“өндрийн-түвшин”** болгох саналтай) гэж далайн дундаж түвшнээс хэмжсэн, түвшин, цэг, эсхүл цэг гэж үзсэн байгууламжийн **босоо зай**”;

“Level / Түвшин гэж нислэгт байгаа агаарын хөлгийн **босоо байршилтай** холбоотой **өндөр, өндрийн-түвшин**, эсхүл **нислэгийн түвшнийг** илэрхийлдэг олон утгатай ерөнхий ойлголт”

Дээрх 2 тодорхойлолт нь 2-уулаа далайн дундаж түвшнээс дээших агаарын хөлгийн босоо байршлыг илэрхийлдэг ижил ойлголт тул **“altitude”-ийг “түвшин”, эсхүл “өндрийн-түвшин” гэж хэрэглэж хэвшвэл зөрчил үүсгэхгүй гэж үзэж байна.**

Дүгнэлт

Altitude, height, level and elevation зэрэг үгсийг хуучин болон шинэчлэгдсэн ИНД-д хэрэглэсэн байдал, засах санал:

Англи		Хуучин ИНД-д:		Батлагдсан ИНД-д	“Altitude”-ийг “өндрийн-түвшин” гэж засах санал	ИНД-д орсон тоо
NZCAR	NZCAR -д орсон тоо	Хэрэглэсэн нэр томьёо	ИНД-д орсон тоо			
Altitude - 19 ИНД-д	246	- <u>үнэмлэхүй өндөр</u> , - өндөр	52 247	Түвшин	Өндрийн-түвшин	246
Height - 21 ИНД-д	192	- <u>харьцангуй өндөр</u> , - өндөр	26 559	Өндөр	Өндөр	200
Level - 36 ИНД	244	- түвшин, - өндөр, - өндрийн цуваа, - өндрийн цуваачлал, - цуваа, - цуваачлал, - цувааны өндөр, - босоо цуваачлал	545 371 11 8 65 4 4 1	Түвшин	Түвшин	299
Flight level - 5 ИНД-д	69	- нислэгийн түвшин, - нислэгийн өндөр, - нислэгийн өндрийн цуваа, - нислэгийн өндрийн цуваачлал, - нислэгийн цуваа, - нислэгийн цуваачлал, - өндрийн цуваачлал, - цувааны өндөр, - босоо цуваачлал - FL	2 29 6 3 35 3 8 4 1 4	Нислэгийн түвшин	Нислэгийн түвшин	70
Elevation - 7 ИНД-д	23	- өндөр	23	Өндөрлөг	Өндөрлөг	23
Нийт	817	Зөвхөн “өндөр” гэж	806	Зөвхөн “өндөр” гэж		200

Шинээр батлагдсан ИНД-д “**түвшин**” гэж хэрэглэсэн “**altitude**”-ийг “**өндрийн-түвшин**” гэж солих саналыг харьцуулж, аль илүүг нь хүлээн авч, нэг утгаар илэрхийлэн хэрэглэх нь буруу ташаа ойлгох, алдаа гарах нөхцөлийг бүрэн арилгана гэж үзэж байна.

1999 оноос хойш 23 жил ИНД-д нэгдсэн маягаар хэрэглэж сураагүй, гадаад хэлнээс хүчээр махчлан орчуулсан “**үнэмлэхүй өндөр (абсолютная высота)**”, “**харьцангуй өндөр (относительная высота)**”, “**босоо цуваа (эшелон)**” зэрэг монгол хэлэнд түгээмэл хэрэглэдэггүй эдгээр үгсийг засаж, залруулахгүй бол хүчингүй болсон ИНД-д байсан тодорхойгүй, алдаатай байдал цаашид ч хэвээр үргэлжлэх тул ИНД-д олон утгаар хэрэглэж байсан “**Altitude**”, “**Height**”, “**Level**”, “**Flight level**”, “**Elevation**” зэрэг үгсийн орчуулгыг батлагдсан ИНД-д засаж, жигдэлснээр эдгээр үгсийн орчуулга андуурагдахгүй, хоорондоо зөрчилдөхгүйгээр ойлгомжтой болсныг дээрх хүснэгтээс Та бүхэн тодорхой харж болно.

С. ИНД-д зарим мэргэжлийн тогтсон АНГЛИ үг, товчлолыг хэрэглэх талаар

1. Зарим англи үгсийн орчуулгын талаар

Англи	Орос	Хуучин ИНД	Батлагдсан ИНД
radar	радиолокатор	- <i>радиолокатор, радиолокаци, локатор</i>	радар
minimum	минимальный	- <i>минимум</i> - <i>хамгийн бага,</i> - <i>дор хаяж,</i> - <i>ядаж,</i> - <i>багадаа</i>	минимум
maximum	максимальный	- <i>максимум</i> - <i>хамгийн их</i> - <i>дээд</i> - <i>дээд тал нь</i>	максимум
minima	минимум	- <i>хязгаарлалт</i> (limit нь олон төрлийн минима-г батгаасан ойлголт)	минима
glider	планер	- <i>моторгүй онгоц</i>	глайдер
powered glider	мотопланер	- <i>мотортой планер</i>	моторт-глайдер
hang-glider	дельтаплан	- <i>дельтаплан</i>	ханг-глайдер
gyro glider	жироплан	- <i>жироплан</i>	жиро-глайдер
Paraglider	Параплан	- <i>Параплан</i>	Параглайдер
Parasail		- тодорхойлоогүй	Парасэйл
Tandem parachute		- тодорхойлоогүй	Тандем-шүхэр
altimeter	высотамер	- <i>өндөр хэмжигч</i>	алтиметр
category	категория	- <i>ангилал</i> (class, type-тай андуурагддаг)	категори
variant	вариант	- тодорхойлоогүй	вариант
series	сери	- тодорхойлоогүй	сери
modification	модификация	- <i>өөрчлөлт</i> (revision, change, amendment-тай андуурагддаг)	модификаци
configuration	конфигурация	- <i>конфигураци</i>	конфигураци

aerobatic	акробатик	- уран жолоодлого	аэробатик
bulletin	бюллетень	- бюллетень - тойм - товхимол	бюллетен ТОВХИМОЛ
simulator	симулятор	- дадлагажуур	симулятор
turbine powered	турбо двигатель	- турбинт хөдөлгүүр	турбинт-хөдөлгүүртэй
turboshaft	турбовальный	- турбинт голт хөдөлгүүр	турбо-голт
turbojet	турбореактивный	- турбинт тийрэлтэт хөдөлгүүр	турбо-жэт
turboprop	турбовинтой	- сэнст турбинт хөдөлгүүр	турбо-проп
turbofan	турбоконтурный	- сэнст тийрэлтэт хөдөлгүүр	турбо-фэн
heliport	вертодром	- тодорхойлоогүй	хэлипорт
UN number	ООН номер	- Нэгдсэн үндэсний дугаар	UN дугаар
cruise relief pilot	сменный пилот на крейсерском этапе полёта	- чиг шулуун нислэг дахь ээлжийн нисгэгч	аяллын орон нисгэгч
cruising level	крейсерский эшелон	- чиг шулуун нислэгийн түвшин	аяллын түвшин
cruising altitude	крейсерская высота	- чиг шулуун нислэгийн өндөр - нислэгийн үнэмлэхүй өндөр	аяллын түвшин
straight and level flight	горизонтальный полет	- чиг шулуун нислэг	чиг шулуун нислэг
en-route	по маршруту	- чиг шулуун нислэг	нислэгийн замд

Дээрх үгсийг орчуулах монгол үг олддоггүй, эсхүл орчуулга нь ойлгомжгүй болдог тул дараах хуульд заасныг үндэслэн англи үгийг нь хэрэглэх нь зүйтэй.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйл. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага

30.5. Хуулийн төсөлд дараах тохиолдолд гадаад хэлний нэр томъёо хэрэглэж болно:

30.5.1. уг нэр томъёог оноосон нэр монгол хэлэнд байхгүй бол;

30.5.2. уг нэр томъёог олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэж хэвшсэн бол;

30.5.3. уг нэр томъёог Монгол Улсын олон улсын гэрээнд хэрэглэж байгаа бол.

2. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд нийтлэг хэрэглэдэг англи үгийн товчлолыг ИНД-д хэрэглэсэн талаар:

ИНД-үүдэд ашигласан нисэхийн мэргэжлийн товчлолыг орчуулан хэрэглэхгүйгээр англиар хэрэглэх нь аливаа буруу ойлголт, андуурлыг үүсгэдэггүй тул олон улсын жишгээр “ИНД-ийн нэр томъёоны тайлбар” болон AC01-0 “Конвенцийн Хавсралтуудын нэр томъёоны тайлбар”-т тусган, AIP-аар нийтэд зарлан хэрэглэдэг:

Иймд ИНД-үүдэд иргэний нисэхэд түгээмэл хэрэглэгддэг, мэргэжлийн нэр томъёо, түүний товчлолыг дараах байдлаар англиар нь хэрэглэж хэвших нь зүйтэй.

- ACAS (Airborne collision avoidance system) - ACAS (Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем)
- AD (Airworthiness directive) - AD (Нислэгт тэнцэх чадварын удирдамж)
- ADF (Automatic direction-finder) - ADF (Автоматаар чиглэл ологч компас)
- ADS-B (automatic dependent surveillance broadcast) - ADS-B (автомат хамааралтай ажиглалт - радио нэвтрүүлэг)
- ADS-C (automatic dependent surveillance - contract) - ADS-C (автомат хамааралтай ажиглалт - гэрээ)
- AEDRS (Automatic engine data recording system) - AEDRS (Хөдөлгүүрийн өгөгдлийг автоматаар бичих систем)
- AELS (Aircraft Emergency Location System) - AELS (Агаарын хөлгийн ослын байрлал тогтоох систем)
- AFRU (Aerodrome Frequency Response Unit) - AFRU (Аэродромын давтамжийг хариулах нэгж)
- AFS (Aeronautical fixed service) - AFS (Нисэхийн суурин холбооны үйлчилгээ)
- AFTN (Aeronautical fixed telecommunication network) - AFTN (Нисэхийн суурин цахилгаан холбооны сүлжээ)
- AGL (Above ground level) - AGL (Газрын түвшнээс дээш)
- AIP (Aeronautical Information Publication) - AIP (Нисэхийн мэдээллийн эмхэтгэл)
- AIRAC (Aeronautical Information Regulation and Control) – AIRAC (Нисэхийн мэдээллийн зохицуулалт ба хяналт)
- AMEL (Aircraft maintenance engineer licence) - AMEL (Агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн үнэмлэх)
- AMSL (Above mean sea level) - AMSL (Далайн дундаж түвшнээс дээш)
- ANR (Air Navigation Register) - ANR (Агаарын Навигацийн Бүртгэл)
- ASDA (Accelerate-stop distance available) - ASDA (Хөөрөлтийн гүйлтийг зогсоох боломжит зай)
- ASHTAM - ASHTAM (Галт уулын үнсний NOTAM)
- ATCRBS (Air traffic control radio beacon system) - ATCRBS (НХУ-ын радио дохиологч систем)
- ATIS (Automatic terminal information service) - ATIS (Аэродромын автомат мэдээллийн үйлчилгээ)
- ATN (aeronautical telecommunication network) - ATN (нисэхийн цахилгаан холбооны сүлжээ)
- AWIB (Aerodrome and Weather Information Broadcast) - AWIB (Аэродромын болон цаг агаарын мэдээлэл дамжуулагч)
- BRNAV (Basic area navigation) - BRNAV (Навигацийн үндсэн бүс)
- BTPD (Body temperature and pressure dry) - BTPD (Биеийн хэм болон хуурай даралт)
- BTPS (Body temperature and pressure standard) - BTPS (Биеийн хэм болон стандарт даралт)

- CBIP (Certification Board for Inspection Personnel) - CBIP (үзлэг шалгалтын ажилтныг гэрчилгээжүүлэх зөвлөл)
- CDFA (a continuous descent final approach) - CDFA (үргэлжлэн өндөр алдах ойртолтын төгсгөл)
- CMP (Configuration, maintenance and procedures standards document) - CMP (Конфигураци, техник үйлчилгээ болон процедурын стандарт баримт бичиг)
- CVR (Cockpit voice recorder) - CVR (Бүхээгийн дуу чимээ бичигч)
- DA (Decision altitude) - DA (Шийдвэр гаргах түвшин)
- dBm (Power expressed in decibels with a reference level of 1milliwatt) - dBm (1 милливатт түвшнийг децибилээр илэрхийлсэн чадал)
- dBW (Power expressed in decibels with a reference level of 1 watt) - dBW (1 ватт түвшнийг децибилээр илэрхийлсэн чадал)
- DH (Decision height) - DH (Шийдвэр гаргах өндөр)
- DME (Distance measuring equipment) - DME (Зай хэмжих төхөөрөмж)
- EDTO (Extended diversion time operation) - EDTO (Даялалтын хугацааг сунгасан нислэгийн үйл ажиллагаа)
- EET (Estimated elapsed time) - EET (Тооцоот өнгөрөлтийн цаг)
- ELT (AF) (Emergency locator transmitter (automatic fixed) - ELT (AF) (Ослын байрлал дамжуулагч (суурин автомат))
- ELT (Emergency locator transmitter) - ELT (Ослын байрлал дамжуулагч)
- ELT(S) (Emergency locator transmitter (survival) - ELT(S) (Ослын байрлал дамжуулагч (аврах))
- EPIRB (Emergency position indicating radio beacon) - EPIRB (Ослын байршил заагч радио дохиологч)
- ETA (Estimated time of arrival) - ETA (Тооцоот нисэн ирэх цаг)
- ETOPS (Extended-range twin-engine operations) - ETOPS (Хоёр-хөдөлгүүртэй агаарын хөлгийн алсын зайн нислэгийн үйл ажиллагаа)
- FAA (Federal Aviation Administration) - FAA (Холбооны нисэхийн удирдах газар)
- FAF (final approach fix) - FAF (ойртолтын төгсгөлийн цэг)
- FAP (final approach point) - FAP (ойртолтын төгсгөлийн цэг)
- FAR (Federal Aviation Regulations) - FAR (Холбооны Нисэхийн Дүрэм)
- FDPS (Flight data processing system) - FDPS (Нислэгийн өгөгдөл боловсруулах систем)
- FDR (Flight data recorder) - FDR (Нислэгийн өгөгдөл бичигч)
- FIR (Flight information region) - FIR (Нислэгийн мэдээллийн бүс)
- FL (Flight level) - FL (Нислэгийн түвшин)
- FMS (Flight management system) - FMS (нислэгийн удирдлагын систем)
- GLONASS (Russian segment of GNSS) - GLONASS (Глобал навигацийн хиймэл дагуулын системийн Оросын хэсэг)
- GNSS (Global navigation satellite system) - GNSS (Глобал навигацийн хиймэл дагуулын систем)
- GPS (Global positioning system) - GPS (Глобал байршил тогтоох систем)
- GPWS (Ground proximity warning system) - GPWS (Газарт ойртсоныг анхааруулах систем)
- HF (High frequency) - HF (Өндөр давтамж)
- HIGE (hover in ground effect) - HIGE (Газрын нөлөөтэй агаарт тогтох)
- HOGE (hover out of ground effect) - HOGE (Газрын нөлөөгүй агаарт тогтох)

- ICAO (International Civil Aviation Organisation) - ICAO (Олон улсын иргэний нисэхийн байгууллага)
- IFR (Instrument flight rule) - IFR (Хэрэглэлийн нислэгийн дүрэм)
- IFSD (In-flight shutdown) - IFSD (Нислэгт хөдөлгүүр унтрах)
- ILS (Instrument landing system) - ILS (Хэрэглэлээр буулт үйлдэх систем)
- IMC (Instrument meteorological conditions) - IMC (Хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөл)
- INCERFA (uncertainty phase) - INCERFA (Тодорхой бус үе шат)
- LAME (licensed aircraft maintenance engineer) - LAME (Агаарын хөлгийн техник үйлчилгээний үнэмлэхтэй инженер)
- LDA (landing distance available) - LDA (Буултын боломжит зай)
- LRNS (long range navigation system) - LRNS (Алсын зайн навигацийн систем)
- MCTOW (Maximum certificated take-off weight) - MCTOW (Гэрчилгээжсэн максимум хөөрөлтийн жин)
- MDA (Minimum descent altitude) - MDA (Өндөр алдах минимум түвшин)
- MDH (Minimum descent height) - MDH (Өндөр алдах минимум өндөр)
- MEL (Minimum equipment list) - MEL (минимум төхөөрөмжийн жагсаалт)
- METAR (Aerodrome routine meteorological report) - METAR (Аэродромын цаг уурын бодит мэдээ)
- MLS (Microwave landing system) - MLS (Буулт үйлдэх хэт богино долгионы систем)
- MMEL (Master minimum equipment list) - MMEL (мастер минимум төхөөрөмжийн жагсаалт)
- MNPS (Minimum navigation performance specifications) - MNPS (Навигацийн минимум үзүүлэлтийн тодорхойлолт)
- MTOPP (Mean Tracheal Oxygen Partial Pressure) - MTOPP (Мөгөөрсөн хоолойн хүчилтөрөгчийн хэсэгчилсэн дундаж даралт)
- MZFW (Maximum zero fuel weight) - MZFW (Түлшгүй максимум жин)
- NANU (Notice Advisory to NAVSTAR User (GPS NOTAM)) - NANU (NAVSTAR хэрэглэгчид хандсан анхааруулах мэдэгдлийг (GPS NOTAM))
- NDB (Non-directional radio beacon) - NDB (Чиглүүлэгч радио дохиологч)
- NM (nautical mile) - NM (далайн миль)
- PAR (Precision approach radar) - PAR (Нарийвчлалтай ойртолтын радар)
- PIB (Pre-flight Information Bulletin) - PIB (Нислэгийн өмнөх мэдээллийн товхимол)
- PLB (Personal locator beacon) - PLB (Хувийн байрлал дохиологч)
- PMA (Parts Manufacturing Approval) - PMA (Эд анги үйлдвэрлэх зөвшөөрөл)
- PSR (Primary surveillance radar) - PSR (Ажиглалтын үндсэн радар)
- QFE (Atmospheric pressure at aerodrome level or at runway threshold) - QFE (Аэродромын, эсхүл ХБЗ-ны босгоны түвшин дэх атмосферийн даралт)
- QNH (An altimeter sub-scale setting to obtain elevation when on the ground) - QNH (Газарт тухайн өндөрлөгийг тодорхойлох зорилгоор алтиметрийн даралтын цонхны заалтыг тохируулах)
- RDPS (Radar data processing system) - RDPS (Радарын өгөгдөл боловсруулах систем)
- RESA (Runway end safety area) - RESA (ХБЗ-ны төгсгөлийн аюулгүйн талбай)
- RFDPS (Radar and flight data processing system) - RFDPS (Радар болон нислэгийн өгөгдөл боловсруулах систем)

- RNAV (Area navigation) - RNAV (Бүсийн навигаци)
- RNP (Required navigation performance) - RNP (Навигаци шаардлагатай үзүүлэлт)
- RVSM (Reduced vertical separation minimum) - RVSM (Багасгасан босоо зайчлалын минимум)
- SARTIME (Search and rescue required time) - SARTIME (Эрэн хайх, авран туслах үйлчилгээ шаардлагатай цаг)
- SB (Service bulletin) - SB (сервис бюллетен)
- SEIFR (Single-engine IFR) - SEIFR (Ганц-хөдөлгүүрт IFR)
- SELCAL (Selective calling system) - SELCAL (Сонгож дуудах систем)
- SFAR (Special Federal Aviation Regulations issued by the Federal Aviation Administration) - SFAR (FAA-ийн гаргасан Холбооны Нисэхийн Тусгай дүрэм)
- SMS (Safety management system) - SMS (Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо)
- SSP (State safety program) - SSP (Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөр)
- SSR (Secondary surveillance radar) - SSR (Ажиглалтын хоёрдогч радар)
- STC (Supplemental Type Certificate) - STC (Нэмэлт маягийн гэрчилгээ)
- STPD (Standard temperature and pressure dry) - STPD (Стандарт хэм болон хуурай даралт)
- TALPA (Take-off and Landing Performance Assessment) - TALPA (Хөөрөлт болон буултын үзүүлэлтийн үнэлгээ)
- TAWS (Terrain awareness and warning system) - TAWS (Саадыг мэдэрч, анхааруулах систем)
- TA (Transition altitude) - TA (Шилжих түвшин)
- TCAD (Traffic alert and collision avoidance device) - TCAD (Хөдөлгөөнийг анхааруулах ба мөргөлдөхөөс зайлсхийх хэрэгсэл)
- TCAS (Traffic alert and collision avoidance system) - TCAS (Хөдөлгөөнийг анхааруулах ба мөргөлдөхөөс зайлсхийх систем)
- TCDS (Type Certificate Data Sheet) - TCDS (Маягийн гэрчилгээний өгөгдлийн хуудас)
- TL (Transition level) - TL (Шилжих нислэгийн түвшин)
- TODA (Take-off distance available) - TODA (Хөөрөлтийн боломжит зай)
- TORA (Take-off run available) - TORA (Хөөрөлтийн гүйлт үйлдэх боломжит зай)
- TSO (Technical Standard Order) - TSO (Техникийн стандартын ордер)
- UTC (Co-ordinated universal time) - UTC (Олон улсын цаг)
- VFR (Visual flight rules) - VFR (Ил харааны нислэгийн дүрэм)
- VHF (Very high frequency) - VHF (Хэт өндөр давтамж)
- VMC (Visual meteorological conditions) - VMC (Ил харааны нислэгийн цаг уурын нөхцөл)
- VOLMET (Meteorological information for aircraft in flight) - VOLMET (Нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт зориулсан цаг уурын мэдээ)
- VOR (VHF omnidirectional radio range) - VOR (Бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч)